



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2011 оны 06 сарын 08 өдөр

Дугаар 207

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн “Журам батлах тухай” 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”, “Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар батлагдсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам”-ыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 9 дугаар сарын 8-ны өдрийн “Гадаадад сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулах тухай” 391 дугаар тушаалын Оросоогийн Чулуунбилэгтэй холбогдолтой хэсгийн “1 жилийн хугацаатайгаар” гэснийг “2 жилийн хугацаатайгаар”, Жадамбаагийн Сувдаатай холбогдолтой хэсгийн “Уэлсийн их сургуулийн магистрантурт төсвийн бодлогын чиглэлээр” гэснийг “Вэсминтэрийн их сургуулийн магистрантурт олон улсын бизнес эдийн засгийн чиглэлээр”, 2010 оны 9 дугаар сарын 10-ны өдрийн “Гадаадад сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулах тухай” 394 дугаар тушаалын Жамьяансэнгээгийн Эрдэнэболдтой холбогдолтой хэсгийн “Австралийн Валийн их сургуулийн магистрантурт” гэснийг “АНУ-ын Режисийн их сургуулийн магистрантурт” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД



Ё.ОТГОНБАЯР